



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.1-т заасныг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлэх 2,481,114,144.67 (Хоёр тэрбум дөрвөн зуун наян нэгэн сая нэг зуун арван дөрвөн мянга нэг зуун дөчин дөрвөн төгрөг жаран долоон мөнгө) төгрөгийн өртөг бүхий хавсралтад заасан инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100078

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн  
дугаар тогтоолын хавсралт



Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийслэлийн өмчид  
үнэ төлбөргүй шилжүүлэх инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж

Д/д	Байршил	Нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Бүртгэх байгууллага
1	Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, 39А байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2020	26,691,145.00	иргэн Д.Буянжаргал	"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ
2	Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, 38 дугаар байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2019	72,758,000.00	"ЗД констракшн" ХХК	
3	Баянгол дүүргийн 15-р хороо, 30/1 дүгээр байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2007	18,669,916.00	"Монжигүүр" ХХК	
4	Хан-Уул дүүргийн 18 дугаар хороо, 26А, 26Б, 26В, 26Г байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2022	1,305,718,825.00	"Тайм констракшн" ХХК	
5	Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны 215 дугаар байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2021	56,034,000.00	иргэн Г.Батсүхийн захиалгаар "Дарцагт ноёд групп" ХХК	
6	Баянгол дүүргийн 19 дугаар хорооны 66А байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2021	76,319,267.00	иргэн Ц.Оюунжав, "Глобал бридж констракшн" ХХК	
7	Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр хорооны Буман-Өлзий хорооллын 754, 755, 756, 757, 759, 760, 761, 762, 763, 764, 765 дугаар байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2015	630,164,662.00	"Ти Си Ди" ХХК	
8	Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны 8В байр	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2019	160,588,629.67	"Зайсан Стэлс" ХХК	
9	Баянгол дүүргийн 31 дүгээр хороо Баруун Ард Аюушийн 2-р гудамж	Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж	2008	134,169,700.00	иргэн С.Алтангэрэл, Б.Баярханд, Б.Мэнджаргал, н.Цэдэвсүрэн	
Нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгийн дүн				2,481,114,144.67		